



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/183

Улаанбаатар хот

Г Автомашины гүйлтийн лимитийн
хязгаарыг шинэчлэн батлах тухай Г

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дугаар тогтоол, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 2.2, 3.27.17, 3.27.18 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын шаардлага болон алслагдсан байршлын онцлог зэргийг харгалзан технологийн зориулалтын автомашины тоо, гүйлтийн лимитийг хавсралтаар баталсугай.

2. Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн, зогсолтгүй явуулах, бэлэн байдалд ажиллах зайлшгүй шаардлагыг харгалзан үйлдвэрлэлийн технологи, дуудлага, нийтийн үйлчилгээний зориулалтын автомашины тоо, гүйлтийн лимитийн судалгааг гаргаж, баталж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д даалгасугай.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шилжүүлэх автомашины судалгааг гаргаж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Хатанбаатар), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

4. Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжийн бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хийлгэх ажлыг зохих журмын дагуу 2022 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Т.Хатанбаатар), Дотоод аудитын алба (Н.Мөнхсүрэн)-нд тус тус даалгасугай.

6. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 204 дугаар тогтоол батлагдаж 2015 оны А/380 дугаар тогтоол хүчингүй болсондой холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны А/143, 2015 оны А/380 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

ДАРГА

С.МОНХНАСАН



Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн
6 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Технологийн зориулалтаар
ашиглах автомашины гүйлтийн лимит

1. Суудлын автомашинаар хотод хөдөлгөөнд оролцох (автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см3-ээс илүүгүй байх):

№	Үйлчлэх салбар, нэгж	Үйлчилгээний зориулалт	Үйлчлэх хоног	Хоногийн гүйлтийн лимит
1	Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга	Технологийн	Хуанлийн	80
2	Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга	Технологийн	Хуанлийн	80
3	Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын үйлчилгээ	технологийн	Ажлын	120
4	Иргэний нисэхийн ерөнхий газрын Захиргаа, хүний нөөц, бичиг хэргийн үйлчилгээ	Технологийн	Хуанлийн	120
5	Иргэний нисэхийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын болон аж ахуйн үйлчилгээ	Технологийн	Хуанлийн	120

--- 00 ---